



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

# **ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

## **2026 оны I улирал**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 04 сарын 20  
Улаанбаатар хот

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

## Үзүүлэлт

## Тодорхойлолт\*

<b>Тээсэн ачаа</b>	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
<b>Ачаа эргэлт</b>	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
<b>Тээсэн зорчигч</b>	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
<b>Зорчигч эргэлт</b>	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
<b>Шилжүүлсэн тн.км</b>	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
<b>Тээврийн орлого</b>	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

## ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯНЗУЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГЭРЭЛНЯМ

## БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗААЯ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

## **АГУУЛГА**

<b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>5</b>
1.1. АЧАА ТЭЭВЭР .....	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	7
<b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР .....</b>	<b>8</b>
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА .....	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	8
<b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>	<b>9</b>
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА .....	9
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ .....	12
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>	<b>13</b>
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА .....	13
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	14
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ .....	15
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ .....	17
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ .....	18
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>18</b>

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	9
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	13
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	14
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	15
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	16
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	17

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутгийн зорчигч.....	7
Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 8. Автотээврийн зорчигч.....	8
Зураг 9.Төмөр замын ачаа .....	9
Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	10
Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	10
Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31.....	11
Зураг 15. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	11
Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор.....	12
Зураг 18. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	13
Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	13
Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	13
Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	14
Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	14
Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	15
Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар.....	16
Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	16
Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	17
Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	17

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны I улирал

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>2</sup>

Хүснэгт 1


№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
				3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	6,422.7	18,412.3	11,447.9	28,556.8	55.1%
		Төмөр зам	мян.тн	3,403.1	10,301.5	5,403.1	14,948.5	45.1%
		Агаар	мян.тн	0.7	2.0	0.7	2.1	1.6%
		<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>9,826.5</b>	<b>28,715.8</b>	<b>16,851.6</b>	<b>43,507.3</b>	<b>51.5%</b>
2	Дамжин өнгөрсөн ачаа	Төмөр зам	мян.тн	518.7	1,389.9	519.0	1,427.4	2.7%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	907.0	2,773.1	1,006.4	2,983.1	7.6%
		Автотээвэр	мян.тн	6,166.5	17,749.6	11,139.8	27,849.8	56.9%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>7,073.6</b>	<b>20,522.8</b>	<b>12,146.2</b>	<b>30,833.0</b>	<b>50.2%</b>
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	266.3	887.1	433.6	1,233.9	39.1%
		Автотээвэр	мян.тн	256.2	662.6	308.0	706.9	6.7%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>522.5</b>	<b>1,549.7</b>	<b>741.7</b>	<b>1,940.9</b>	<b>25.2%</b>
5	Дотоод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,711.0	5,251.3	3,444.1	9,304.0	77.2%
		Агаар	мян.тн	0.7	2.0	0.7	2.1	1.6%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>1,711.7</b>	<b>5,253.3</b>	<b>3,444.7</b>	<b>9,306.0</b>	<b>77.1%</b>
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	970.5	2,885.1	1,619.6	4,036.1	39.9%
		Төмөр зам	сая тн.км	1,795.9	5,201.9	2,212.8	6,307.1	21.2%
		Агаар	сая.тн.км	2.0	5.7	2.2	6.7	16.5%
		<b>Нийт</b>	<b>сая тн.км</b>	<b>2,768.4</b>	<b>8,092.7</b>	<b>3,834.6</b>	<b>10,349.9</b>	<b>27.9%</b>
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	13,055.2	38,637.2	18,618.0	48,694.8	26.0%
		Төмөр зам	мян.хүн	138.0	399.2	143.0	397.4	-0.5%
		Агаар	мян.хүн	148.1	479.3	172.0	532.9	11.2%
		<b>Нийт зорчигч</b>	<b>мян.хүн</b>	<b>13,341.3</b>	<b>39,515.7</b>	<b>18,933.0</b>	<b>49,625.1</b>	<b>25.6%</b>
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	16.8	70.4	17.6	58.4	-17.0%
		Төмөр зам	мян.хүн	2.1	7.2	2.8	7.7	7.0%
		Агаар	мян.хүн	114.3	380.8	138.5	437.3	14.8%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>133.1</b>	<b>458.4</b>	<b>158.8</b>	<b>503.4</b>	<b>9.8%</b>
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	124.3	378.7	109.2	383.5	1.3%
		Төмөр зам	мян.хүн	135.9	392.0	140.3	389.7	-0.6%
		Агаар	мян.хүн	33.9	98.5	33.5	95.6	-3.0%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>294.0</b>	<b>869.3</b>	<b>283.0</b>	<b>868.8</b>	<b>-0.1%</b>
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,914.1	<b>38,188.0</b>	18,491.2	<b>48,252.9</b>	<b>26.4%</b>
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	128.3	400.6	121.3	405.7	1.3%
		Төмөр зам	сая хүн.км	56.5	167.3	61.1	169.5	1.3%
		Агаар	сая хүн.км	403.4	1,325.1	391.7	1,391.5	5.0%
		<b>Нийт</b>	<b>сая хүн.км</b>	<b>588.2</b>	<b>1,893.1</b>	<b>574.1</b>	<b>1,966.7</b>	<b>3.9%</b>
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	877.0	2,800.0	1,037.0	3,257.0	16.3%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	742.0	2,054.0	800.0	2,124.0	3.4%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	6,332.0	18,251.0	7,726.0	21,522.0	17.9%

<sup>2</sup> Зам, тээврийн салбарын 2026 оны нэгдүгээр улирлын статистикийн мэдээг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2026 оны 3 дугаар сард 16.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 71.5%-аар өссөн. Харин 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 43.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2026 оны 3 дугаар сард 11.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 78.2%-аар өссөн. Үүнээс экспортод 11.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 80.6%-аар өссөн бол импортоор 308.0 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 6.7%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 1 дүгээр улирлын байдлаар 28.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55.1%-аар өссөн байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 3 дугаар сард 5.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58.8%-аар өссөн. Харин өссөн дүнгээр буюу 1 дүгээр улирлын байдлаар нийт 14.9 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оноос 45.1%-аар өссөн байна. Үүнээс дотоодын ачаа 9.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 77.2%-аар, дамжин өнгөрсөн ачаа 1.4 сая тонн болж 2.7%-аар, импортын ачаа 1.2 сая тонн болж 39.1%-аар, экспортын ачаа 3.0 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 7.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Агаарын тээврээр 2026 оны 3 дугаар сард 680.2 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 3.4%-аар буурсан бол 1 дүгээр улирлын байдлаар нийт 2.1 мянган тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6%-аар өссөн байна



Экспортоор 2026 оны 1 дүгээр улиралд 30.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.2%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 3.0 сая тонн тээвэрлэсэн нь 7.6%-аар, автотээврээр 27.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 56.9%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээврийн ачаа 90%-ийг, төмөр замын ачаа 10%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2026 оны 1 дүгээр улиралд нийт 1.9 сая тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.2%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 1.2 сая тонн ачаа импортолсон нь 39.1%-аар, автотээврээр 706.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.7%-аар тус тус өссөн байна. Импортын тээврийн 64%-ийг төмөр замаар, 36%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/





## 1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2026 оны 3 дугаар сард 18.9 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 41.9%-аар өссөн. Эхний улирлын байдлаар 49.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 25.6%-аар өсжээ.

- 2026 оны 3 дугаар сард автотээврээр сард 18.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.6%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 109.2 мянган зорчигч (-12.1%), олон улсад 17.6 мянган зорчигч (+4.8%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 18.5 сая зорчигч (+43.2%) тус тус зорчсон байна. Харин 1 дүгээр улиралд нийт 48.7 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.0%-аар өссөн байна. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замын тээврээр 2026 оны 3 дугаар сард нийт 143.0 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.7%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр нийт 397.4 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 0.5%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 7.0%-аар өссөн бол орон нутагт 389.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 0.6%-аар буурчээ.
- Агаарын тээврээр 3 дугаар сард 172.0 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.1%-аар өссөн байна. Өссөн дүнгээр нийт 532.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.2%-аар өссөн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч

Олон улсад нийт 503.4 мянган зорчигч (+9.8%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 437.3 мянган зорчигч (+14.8%), автотээврээр 58.4 мянган зорчигч (-17.0%), төмөр замаар 7.7 мянган зорчигч (+7.7%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 87%, автотээвэр 12%, төмөр зам 1%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 5/

Орон нутагт нийт 868.8 мянган зорчигч (-0.1%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 383.5 мянган зорчигч (+1.3%), төмөр замаар 389.7 мянган зорчигч (-0.6%), агаарын тээврээр 95.6 мянган зорчигч (-3.0%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**

**2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА**

2026 оны эхний улиралд авто замаар 28.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 55.1%-аар өслөө.

Хүснэгт 2


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>6,422.7</b>	<b>18,412.3</b>	<b>11,447.9</b>	<b>28,556.8</b>	<b>55.1%</b>
Импорт	мян.тн	256.2	662.6	308.0	706.9	6.7%
Экспорт	мян.тн	6,166.5	17,749.6	11,139.8	27,849.8	56.9%
Ачаа эргэлт	сая тн.км	970.5	2,885.1	1,619.6	4,036.1	39.9%

2026 оны 3 дугаар сард автотээврээр 11.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 78.2 хувиар өссөн байна. Үүнээс экспортод 11.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 80.9%-аар өссөн бол импортоор 308.0 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 20.2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2026 оны I дүгээр улирлын байдлаар автотээврээр нийт 28.6 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55.1%-аар өссөн байна.

Ачаа эргэлт 2026 оны 3 дугаар сард 1,619.6 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үеэс 66.9%-аар өссөн байна. Харин 2026 оны I дүгээр улирлын байдлаар 4,036.1 сая тонн.км болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.9%-аар өссөн үзүүлэлттэй байна.байна.

Ачаа тээврийн 98%-ийг экспортын ачаа, 2%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа 99.8% эзэлж байгаа бол үүнээс нүүрс 96.9%-ийг эзэлж байна. /Зураг 7/

2026 оны 3 дугаар сард авто замаар 10.9 сая тонн нүүрс экспортод гарсан. Харин өссөн дүнгээр 27.0 сая тонн нүүрс автозамаар экспортод гарчээ.




**2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ**

Хүснэгт 3

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	<b>13,055,179</b>	<b>38,637,157</b>	<b>18,618,024</b>	<b>48,694,832</b>	<b>26.0%</b>
Олон улсад	хүн	16,795	70,401	17,599	58,406	-17.0%
Орон нутагт	хүн	124,256	378,738	109,224	383,536	1.3%
Хот доторх нийтийн тээвэр	хүн	12,914,128	38,188,018	18,491,201	48,252,890	26.4%
Зорчигч эргэлт	сая хүн.км	128.3	400.6	121.3	405.7	1.3%

Зураг 8. Зорчигч тээвэр



олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 8/

Автотээвэрээр 2026 оны 3 дугаар сард 18.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.6%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 109.2 мянган зорчигч (-12.1%), олон улсад 17.6 мянган зорчигч (+4.8%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 18.5 сая зорчигч (+43.2%) тус тус зорчсон байна.

1 дүгээр улиралд нийт 48.7 сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.0%-аар өссөн байна.

Автотээврийн зорчигчийн 99.1%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 0.8%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.1%-ийг

### БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР


#### 3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээвэрээр 2026 оны эхний улиралд 14.9 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.1%-аар өслөө.


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралты % 2026.1/2025.1
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Ачаа тээвэрлэлт</b>	<b>мян.тн</b>	<b>3,403.1</b>	<b>10,301.4</b>	<b>5,403.1</b>	<b>14,948.5</b>	<b>45.1%</b>
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,730.0	8,298.3	3,017.2	9,059.8	9.2%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	184.8	487.3	1,321.5	3,272.7	571.5%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	121.1	443.0			
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	330.2	937.5	350.8	941.6	0.4%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	36.9	135.3	713.5	1,674.4	1138.0%
Дотоодын ачаа	мян.тн	1,711.0	5,251.3	3,444.1	9,304.0	77.2%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	1,038.0	3,248.2	1,058.2	3,415.2	5.1%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	184.8	487.3	1,321.5	3,272.7	571.5%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	121.1	443.0			
"Монголиантранс Ложистик" ХХК	мян.тн	330.2	937.5	350.8	941.6	0.4%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	36.9	135.3	713.5	1,674.4	1138.0%
Импорт ачаа	мян.тн	266.3	887.1	433.6	1,233.9	39.1%
БНХАУ-аас	мян.тн	75.1	207.7	117.4	380.3	83.1%
ОХУ-руу	мян.тн	191.2	679.4	316.2	853.7	25.6%
Экспорт ачаа	мян.тн	907.0	2,773.1	1,006.4	2,983.1	7.6%
БНХАУ-руу	мян.тн	893.7	2,734.5	997.8	2,950.6	7.9%
ОХУ-руу	мян.тн	13.3	38.8	8.7	32.6	-16.0%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	518.7	1,389.9	519.0	1,427.4	2.7%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	134.1	409.3	173.4	487.3	19.0%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	384.6	980.6	345.6	940.1	-4.1%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,795.9	5,202.0	2,212.8	6,307.1	21.2%

Төмөр замын тээвэрээр 2026 оны 3 дугаар сард 5.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58.8%-аар өссөн байна. Харин 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 14.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.1%-аар өссөн үзүүлэлттэй байна. Тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл дотоодын ачаа 9.3 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 77.2%-аар, импортын ачаа 1.2 сая тонн болж 39.1%-аар, экспортын ачаа 3.0 сая тонн болж 7.6%-аар, дамжин өнгөрөх ачаа 1.4 сая тонн болж 2.7%-аар тус тус өссөн байна. /Хүснэгт 4/

Зураг 9. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




2026 оны 1 дүгээр улирлын байдлаарх нийт ачаа тээврийн 9.1 сая тонн буюу 61%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 3.3 сая тонн буюу 22%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 941.6 мянган тонн буюу 6%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 1.7 сая тонн ачаа буюу нийт ачааны 11%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 10/

Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл 9.3 сая тонн буюу 62%-ийг дотоодын ачаа, 3.0 сая тонн буюу 20%-ийг экспортын ачаа, 1.4 сая тонн буюу 10%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 1.2 сая тонн буюу 8%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 11/

Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл




**Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**




Дотоодод тээвэрлэсэн 9.3 сая тонн ачааны 3.4 сая тонн ачаа буюу 35%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 3.3 сая тонн буюу 35%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 941.6 мянган тонн ачаа буюу 10%-ийг "Монголиантранс Логистик" ХХК, 1.7 сая тонн буюу 18%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 12/

2026 оны I дүгээр улиралд байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 100.7 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 36.4 мянган тонн, "МТЛожистик" ХХК нь 10.5 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 18.6 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 13/

**Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар**




**Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2026.03.31**



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуус оруулав. 2026 оны эхний 3 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 103.4 мянга, экспортын ачаа 33.1 мянга, дамжин өнгөрсөн ачаа 15.9 мянга, импортод дундажаар 13.7 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 14/

2025.01.01-2026.03.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 15/


Зураг 15 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



### 3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Хүснэгт 5 Өсөлт бууралтын % 2026.1/2025.1
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Зорчигч тээвэрлэлт</b>	<b>мян.хүн</b>	<b>138.0</b>	<b>399.2</b>	<b>143.0</b>	<b>397.4</b>	<b>-0.5%</b>
Олон улс	мян.хүн	2.1	7.2	2.8	7.7	7.0%
Орон нутаг	мян.хүн	135.9	392.0	140.3	389.7	-0.6%
Зорчигч эргэлт	сая хүн.км	56.5	167.4	61.1	169.5	1.3%


Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр



2026 оны 3 дугаар сард 143.0 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6%-аар өссөн байна. Харин өссөн дүнгээр буюу 2026 оны 1 дүгээр улиралд нийт 397.4 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 0.5%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 7.0%-аар өссөн боловч орон нутагт 389.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 0.6%-аар буурчээ.

Зорчигч эргэлт 3 дугаар сард 61.1 сая хүн км болсон нь өмнөх оны 3 дугаар сараас 8.1%-аар өссөн байна. 1 дүгээр улирлын дүнгээр 169.5 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 1.3%-аар өсжээ. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор




2025.01.01-2026.03.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос нэгтгэн гаргав. 2026 оны 1 дүгээр улиралд төмөр замаар хоногт дундажаар 4.4 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 17/

#### БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

##### 4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
			3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	<b>Нийт ачаа, шуудан тээвэр</b>	ТН	<b>704.0</b>	<b>2,026.0</b>	<b>680.2</b>	<b>2,058.2</b>	<b>1.6%</b>
2	олон улсад	ТН	699.0	2,016.6	675.7	2,045.8	1.4%
3	орон нутагт	ТН	5.0	9.4	4.5	12.4	32.4%
4	<b>Нийт ачаа</b>	ТН	<b>688.0</b>	<b>1,974.4</b>	<b>663.7</b>	<b>2,011.4</b>	<b>1.9%</b>
5	олон улсад	ТН	683.0	1,965.0	659.2	1,999.0	1.7%
6	орон нутагт	ТН	5.0	9.4	4.5	12.4	32.3%
7	<b>Нийт шуудан</b>	ТН	<b>16.0</b>	<b>51.6</b>	<b>16.5</b>	<b>46.8</b>	<b>-9.3%</b>
8	олон улсад	ТН	16.0	51.6	16.5	46.8	-9.3%
9	орон нутагт	ТН	0.0	0.0	0.0	0.0	
10	<b>Ачаа, шуудан эргэлт</b>	МЯН.ТН-КМ	<b>1,975.5</b>	<b>5,743.2</b>	<b>2,194.9</b>	<b>6,693.0</b>	<b>16.5%</b>
11	олон улсад	МЯН.ТН-КМ	1,972.8	5,738.2	2,192.5	6,686.2	16.5%
12	орон нутагт	МЯН.ТН-КМ	2.7	5.0	2.4	6.8	35.6%



Агаарын тээврээр 2026 оны 3 дугаар сард 680.2 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4%-аар буурсан байна. Үүнээс ачаа 663.7 тонн болж өмнөх оны мөн үеэс 3.5%-аар буурсан бол шуудан 16.5 тонн болж 3.1%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 18/

Харин 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 2.1 мянган тонн ачаа, шуудан


тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6%-аар өссөн байна.

Олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 2,045.2 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 1.4%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 12.4 тонн болж өмнөх оны мөн үеэс 32%-аар тус тус өссөн байна. /Зураг 19/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.4%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.6%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 98%-ийг ачаа эзэлж байгаа бол 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2026 оны эхний 2 сард 6.7 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 16.5%-аар өсжээ.

Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




#### 4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2026 оны эхний улиралд нийт 532.9 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 11.2%-аар өслөө.

Хүснэгт 7

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	<b>148,113</b>	<b>479,349</b>	<b>171,979</b>	<b>532,884</b>	<b>11.2%</b>
Олон улсад	хүн	114,262	380,808	138,493	437,298	14.8%
Орон нутагт	хүн	33,851	85,394	33,486	95,586	-3.0%
<b>Зорчигч эргэлт</b>	<b>мян.хүн км</b>	<b>403,399.6</b>	<b>1,325,137.4</b>	<b>391,714.3</b>	<b>1,391,547.2</b>	<b>5.0%</b>
Олон улсад	мян.хүн км	383,635.0	1,267,379.6	371,956.8	1,335,516.4	5.4%
Орон нутагт	мян.хүн км	19,764.6	57,757.8	19,757.5	56,030.8	-3.0%

Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо




2026 оны 3 дугаар сард агаарын тээврээр нийт 172.0 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.1%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 138.5 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 21.2%-аар өссөн бол орон нутагт 33.5 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 1.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Өссөн дүнгээр нийт 532.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 11.2%-аар өссөн байна. /Хүснэгт 7/

Зорчигч эргэлт 2026 оны 3 дугаар сард 391.7 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9%-аар буурсан бол өссөн дүнгээр буюу 1 дүгээр улирлын байдлаар 1,391.5 сая хүн км болж өмнөх оны мөн үеэс 5.0%-аар өссөн байна.

Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар



Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 22/

#### 4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.1/2025.1
		3 дугаар сар	Өссөн дүн	3 дугаар сар	Өссөн дүн	
1	<b>Олон улсад</b>	<b>114,262</b>	<b>380,808</b>	<b>138,493</b>	<b>437,298</b>	<b>14.8%</b>
2	чиглэл Сөүл	35,862	110,394	42,021	128,336	16.3%
3	Бээжин	20,866	58,174	25,406	65,271	12.2%
4	Токио	10,562	28,958	14,297	37,049	27.9%
5	Истанбул	9,317	28,021	10,165	27,940	-0.3%
6	ХонКонг	7,771	24,906	9,284	26,484	6.3%
7	Франкфурт	5,177	14,906	7,996	18,963	27.2%
8	Бангкок	2,425	13,558	1,224	12,079	-10.9%
9	Фукуок	1,376	18,831	0	17,697	-6.0%
10	Хөх хот	4,321	14,244	7,924	21,162	48.6%
11	Санья/Хайнань	2,463	9,583	3,112	14,463	50.9%
12	Пукет	1,065	9,405	708	8,397	-10.7%
13	Хо Ши Мин	2,082	11,068	0	6,082	-45.0%
14	Эрээн			4,105	11,152	
15	Алмата	1,588	4,961	1,803	4,860	-2.0%
16	Эрхүү	1,345	3,731	1,424	3,568	-4.4%
17	На Транг		3,585	444	4,375	22.0%
18	Хайкоу/Хайнань	681	3,892	1,223	3,243	-16.7%
19	Красноярск	197	590	207	393	-33.4%
20	Ордос	1,184	3,319	0	4,356	31.2%
21	Шанхай			3,186	4,567	
22	Бусад чиглэлд	5,980	18,682	3,964	16,861	-9.7%

2026 оны 1 дүгээр улирлын байдлаар олон улсын нислэгээр нийт 437.3 мянган зорчигч тээвэрлэсэн нь 2025 оны мөн үеэс 14.8%-аар өссөн үзүүлэлттэй байна.


## Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны I улирал

Чиглэлээр авч үзвэл Сөүл хотын чиглэл хамгийн өндөр зорчигчтой хэвээр байгаа бөгөөд 2026 оны I дүгээр улиралд 128.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 16.3%-аар өссөн байна. Мөн Бээжин чиглэлд 65.3 мянган зорчигч тээвэрлэж 12.2%-аар, Токио чиглэлд 37.0 мянган зорчигч зорчиж 27.9%-аар тус тус өссөн байна.

Европын чиглэлээс Франкфурт чиглэлд зорчигчийн урсгал 27.2%-аар өсч, 19.0 мянгад хүрсэн бол Истанбул чиглэлд 27.9 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 0.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Зүүн болон Зүүн өмнөд Азийн аялал жуулчлалын чиглэлүүдээс ХонгКонг чиглэл 6.3%-аар өсөж, 26.5 мянган зорчигч тээвэрлэсэн бол Бангкок (-10.9%), Пукет (-10.7%), Хо Ши Мин (-45.0%) чиглэлүүдэд зорчигчийн тоо бууралттай байна. Харин Хөх хот чиглэлд зорчигчийн тоо 48.6%-аар, Санья/Хайнань чиглэлд 50.9%-аар, Ордос чиглэлд зорчигчийн урсгал 31.2%-аар тус тус өссөн байна. Нөгөө талаас Красноярск (-33.4%), Эрхүү (-4.4%), Алмата (-2.0%) зэрэг зарим чиглэлүүдэд зорчигчийн тоо буурсан үзүүлэлттэй байна

**Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр**



Дээрх графикт 2026 онд хамгийн их зорчигч зорчсон 20 хотуудыг харуулав. /Зураг 23/

**Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар**




2026 оны I улирлын байдлаар олон улсын нислэгээр зорчсон нийт зорчигчдын 47.1% буюу 205.9 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр зорчсон бол “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 56.0 мянган зорчигч (12.9%), “Air China” компанийн нислэгээр 43.7 мянган зорчигч (10.1%), “Aero Mongolia” ХХК-ийн нислэгээр 35.7 мянган зорчигч (8.2%), “Korean Air” компанийн нислэгээр 34.8 мянган зорчигч (8.0%), “Turkish Airlines”-ийн нислэгээр 17.7 мянга (4.1%), “Jeju Air”-ийн нислэгээр 13.6 мянга (3.1%), “Asiana Airlines”-ийн нислэгээр 11.9 мянга (2.7%), “Juneyao Air” 5.4 мянга (1.2%), “China United Airlines” 3.3 мянга (0.8%), “IRAERO” 3.6 мянга (0.8%), “VietJet Air” 1.8 мянга (0.4%), “KrasAvia” 0.4 мянга (0.1%), бусад агаарын тээвэрлэгчдийн нислэгээр 318 зорчигч (0.1%) тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 24/

#### 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	<b>Орон нутагт зорчигч тээвэр</b>	<b>33,851</b>	<b>98,541</b>	<b>33,486</b>	<b>95,586</b>	<b>-3.0%</b>
2	чиглэл Оюутолгой	29,566	85,394	28,525	80,523	-5.7%
3	Ховд	1,445	3,906	1,484	3,955	1.3%
4	Өлгий	1,117	3,316	1,057	3,127	-5.7%
5	Улаангом	355	1,405	506	1,521	8.3%
6	Улиастай	392	1,438	482	1,551	7.9%
7	Мөрөн	525	1,551	543	2,035	31.2%
8	Алтай	446	1,526	463	1,350	-11.5%
9	Баянхонгор			426	1,373	
10	Бусад чиглэлд	5	5		151	2,920.0%

Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр




2026 оны 3 дугаар сард орон нутагт 33.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1%-аар буурсан байна.

Харин өссөн дүнгээр эхний улиралд 95.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.0%-аар буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлд 80.5 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 5.7%-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

/Хүснэгт 9/

**Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь**



Орон нутагт зорчигчдын 63% буюу 60.5 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 24% буюу 23.2 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 13% буюу 11.9 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 7.3%-аар буурсан бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 3.3%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 9.5%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 26/


### 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10

Үзүүлэлт	2025 он		2026 он		Өсөлт бууралтын % 2026.I/2025.I
	3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
<b>Нийт нислэгийн тоо</b>	<b>7,951</b>	<b>23,105</b>	<b>9,563</b>	<b>26,903</b>	<b>16.4%</b>
Олон улсын өнгөрөлтийн нислэг	6,332	18,251	7,726	21,522	17.9%
Хөөрөлт, буулт	1,619	4,854	1,837	5,381	10.9%
Олон улсын хөөрөлт, буулт	877	2,800.0	1,037	3,257.0	16.3%
Орон нутгийн хөөрөлт, буулт	742	2,054.0	800	2,124.0	3.4%

2026 оны 3 дугаар сард нийт нислэгийн тоо 9.6 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20.3%-аар өссөн байна. 1 дүгээр улирлын байдлаар нийт нислэгийн тоо 26.9 мянга болж өмнөх оны мөн үеэс 16.4%-аар өссөн. Үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 21.5 мянга болж 17.9%-аар, олон улсын хөөрөлт, буулт 3.3 мянга болж 16.3%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 2.1 болж 3.4%-аар тус тус өссөн байна. /Зураг 27/

**Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар**



## ДҮГНЭЛТ

### **Ачаа тээвэр**

2026 оны I улирлын байдлаар улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр нийт 43.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 51.5%-аар өссөн байна. Үүнээс экспортын ачаа 50.2%, импортын ачаа 25.2%, дотоодын ачаа 77.1%, дамжин өнгөрсөн ачаа 2.7%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тээврийн төрлөөр авч үзвэл автотээврийн ачаа тээвэр 55.1%-аар, төмөр замын тээвэр 45.1%-аар, агаарын тээвэр 1.6%-аар өссөн нь нийт өсөлтийн хамгийн өндөр хувийг автотээврийн салбар эзэлж байна. Ялангуяа экспортын ачаанд автотээврийн эзлэх хувь 90 орчим хувийг эзэлж байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлт өндөр байгаатай шууд холбоотой бөгөөд цаашид ч мөн адил экспортын хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад тогтвортой өсөх хандлага үргэлжилж байна. Гэвч дамжин өнгөрөх тээврийн өсөлт харьцангуй бага хэвээр байгаа бөгөөд цаашид дамжин өнгөрөх тээврийн урсгалыг нэмэгдүүлэх, төмөр зам болон боомтын хүчин чадлыг сайжруулах, логистикийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлд бодлогын арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

### **Зорчигч тээвэр**

2026 оны I улиралд бүх төрлийн тээврээр нийт 49.6 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 25.6%-аар өссөн байна. Үүнээс автотээврийн зорчигч 26.0%-аар, агаарын тээврийн зорчигч 11.2%-аар өссөн бол төмөр замын зорчигч тээвэр 0.5%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт өсөлтөд нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийн өсөлт (26.4%) голлон нөлөөлсөн бөгөөд энэ нь хотын хөдөлгөөний эрчим, нийтийн тээврийн хэрэглээ нэмэгдэж байгааг илтгэж байна. Үүнтэй холбоотойгоор цаашид нийтийн тээврийн чанар, хүртээмж, хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Агаарын тээврийн зорчигчийн урсгал өссөн нь олон улсын зорчих хөдөлгөөн идэвхжиж, аялал жуулчлал болон бизнесийн зорчилт нэмэгдэж байгаатай холбоотой байна. Харин орон нутгийн нислэгийн зорчигчийн бууралт нь дотоодын нислэгийн чиглэл, нислэг хийх давтамж болон үнэ тарифтай холбоотой байж болзошгүй байна.

Төмөр замын зорчигч тээврийн бууралт нь үйлчилгээний чанар, хурд, өрсөлдөх чадвартай холбоотой бөгөөд цаашид үйлчилгээний чанарыг сайжруулах, хуваарийг оновчтой болгох, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй юм.